

Монголын хуульчдын холбооны Ерөнхийлөгчид нэр дэвшигч Шагдарсүрэнгийн АЛТАНГАДАС

МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Баримтлах зарчим:

- Нээлттэй ил тод
- Хүртээмжтэй, сайн засаглал
- Хамтын ажиллагаа, бүгдийн оролцоо

Мөрийн хөтөлбөрийг дээрх баримтлах зарчимд уялдуулан дараах байдлаар дэвшүүлж байна. Үүнд:

Нэг. Хуульчдын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлын асуудлаар

- 1.1. Хуульчдын нийгэмд эзлэх байр суурь, нэр хүндийг өргөх, тэдний нэр хүнд унахаас сэргийлэх, түүнчлэн хуульчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
- 1.2. Хороодын үйл ажиллагааг эрчимжүүлэх;
- 1.3. Мэргэжлийн болон холбооны үйл ажиллагаанд гишүүдийн тэгш оролцоо, шударга ёсны тогтолцоог хуульч бүрд тэгш, бүрэн хангах;

Хоёр. Хамтын ажиллагааны асуудлаар

- 2.1. Салбарын болон салбарын бус байгууллагуудтай хамтран ажиллах;
- 2.2. Өмгөөлөгчдийн холбоотой хамтран ажиллаж давхар татварын асуудлыг цэгцлэх;
- 2.3. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд бүс нутгийн хуульчдын холбоодуудтай харилцаа тогтоож хамтран ажиллах;

Гурав. Холбооны үйл ажиллагааг идэвхижүүлэх

- 3.1. Гишүүдийн мэргэжлийн болон бусад сонирхлын хэрэгцээг дэмжихэд чиглэсэн ашиг тустай хөтөлбөр, үйлчилгээгээр хангах;
- 3.2. Сургалтын үйл ажиллагааг гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэх;
- 3.3. Холбооны санхүүгийн байдлыг ил тод нээлттэй байлгах;

Дөрөв. Хуульчдын нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр

- 4.1. Хүмүүнлэгийн болон олон нийтийн санаачилга бүхий төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, холбооноос оролцох боломж бүрдүүлэх;
- 4.2. Нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалах асуудлаар хуульчдыг дэмжих, тэдний үйл ажиллагааг сурталчилан таниулах нөлөөллийн ажилд дэмжлэг үзүүлэх;